

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих - Байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл (I, II шат) (Хөнгөлөлттэй зээл)

Үндэслэл

Монгол улсын эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувь өндөр (ДНБ-ий 30%, экспортын бүтээгдэхүүний 70%) бөгөөд олон улсын бараа бүтээгдэхүүний зах зээл болон хөгжингүй орнуудын эдийн засгийн өөрчлөлтөөс шууд хамааралтай гэх мэт, эдийн засгийн бүтэц сул байна. Үндэсний хэмжээнд бүртгэгдсэн компани, ААН-ийн тоо 2009 оны 12-р сарын байдлаар 64,500-д (үүнээс хувийн компани 46,800) хүрсэн ч тэдний дийлэнх нь жижиг дунд болон гэр бүлийн хүрээний бичил бизнес эрхэлж байна. Монголд цаашид ч уул уурхайн салбарын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт үргэлжлэх төлөвтэй байгаа ч үндэсний хэмжээнд тогтвортой хөгжлийг хангахын тулд ЖДҮ-г олон салбарт дэмжин гаргах, шинээр бизнес эрхлэгчдийг дэмжих шаардлагатай байна. Мөн улам бүр хурцдаж буй хот суурин газрын агаарын бохирдлын эсрэг тэмцэхэд ч хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Агуулга

- Монгол улсын жижиг дунд үйлдвэрт урт хугацааны зээл олгох (Байгаль орчныг хамгаалах ажил багтана)
- Монгол улсад олгох зээлийн дээд хязгаар 10-600 мянган ам.доллар орчим (Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх зээлийн хувьд хязгаарлалт тогтоогоогүй), Эргэн төлөлтийн хугацаа 3-10 жил (Эргэн төлөлтөөс чөлөөлөгдөх хугацаа 0-3 жил), 6-9 хувийн хүүтэй

(Зээлийн нөхцөл: 1-р шат 0.75%, 2-р шат 0.65%-ийн хүүтэй, Эргэн төлөлтийн хугацаа 40 жил (Үүнээс эхний 10 жилд эргэн төлөлтөөс чөлөөлөгдөнө))



Хөрөнгө оруулалт хийгдсэн оёдлын үйлдвэр



Хөрөнгө оруулалт хийгдсэн нарийн боовны үйлдвэр

Үр дүн

Уг төслийн хүрээнд Монгол улсын жижиг дунд, бичил үйлдвэрт бага хүүтэй урт хугацааны зээл олгосноор ажил эрхлэлтийг дэмжиж байна. Эхний шатны зээлээр 145 компанид санхүүжилт олгогдсон бөгөөд 1,300 ажлын байрыг шинээр бий болгосон. Зээлд хамрагдсан ААН-үүдийн 60% нь 20-с доош ажилтантай бичил бизнес эрхлэгчид байсан бөгөөд энэ нь уг зээл жинхэнэ утгаараа

жижиг дунд, бичил бизнес эрхлэгчдийг дэмжиж буйг харуулж байна. Мөн 2-р шатны төслөөр нийт зээлийн төсвийн 80% нь бизнес эрхлэгчдэд хэдийнээ олгогдоод байна. Энэхүү зээлийн хөтөлбөр нь Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлж, аж үйлдвэрийг дэмжигч жижиг дунд, бичил бизнесийг хөгжүүлээд зогсохгүй ядуурлыг бууруулахад ч хувь нэмэр оруулж байна